



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2016 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

*ОНХС-аар гүйцэтгэж байгаа барилга
угсралт, их засварын ажилд захиалагчийн
хяналтыг тавьж ажиллах шаардлагатай
байна.*



2017 ОН

Тайлан бэлтгэсэн:
Архангай аймгийн
аудитын газар

- Товчилсон үгийн тайлбар
- Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
- Аудитын тайлан

Тэргүүлэх аудитор
Д.Уламбаяр
Аудитын менежер
Т.Байгалмаа

Шинжээч
Х.Алтанчимэг
Г.Цог-эрдэнэ

2017 оны
04 дугаар сар

Уг тайланг
www.audit.mn
сайт-аас үзнэ үү

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах зүйл
байвал 70332860
дугаарын утас,
70333141 дугаарын
факсаар харилцана
уу

Хаяг:
Эрдэнэбулган
сум Аймгийн
ЗДТГ-ын байр
3-р давхар 314 тоот

Зорилт 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу төлөвлөж, сумдад олгох шилжүүлгийг бүрэн олгосон байна.

- 1.1 Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.
- 1.2 Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөжээ.
- 1.3 Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна.
- 1.4 Аймгийн ОНХС-аас сумдад олгосон шилжүүлгийг хууль журмын дагуу хуваарилж батлагдсан хуваарийн дагуу олгожээ.

Зорилт 2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд захиалагчийн зүгээс бүрэн хяналт тавьж ажиллаж чадахгүй байна.

- 2.1 ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.
- 2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлж, иргэдийн санал авсан ТАХ-г хэрэгжүүлсэн байна.
- 2.3 ТЭЗҮ, зураг төсөвгүй ажилд хөрөнгө зарцуулах нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.
- 2.4 Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн зарим заалтыг биелүүлэхгүй байна.
- 2.5 ОНХС-ийн хөрөнгийг зарим сумдууд урсгал зардалд зарцуулахаар баталж байна.
- 2.6 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг бүрэн тавьж чадахгүй, ажлын гүйцэтгэл тодорхойгүй байхад санхүүжилтийг олгосоор байна.
- 2.7 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн дагуу бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Зорилт 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн байдалд хууль, журмын хүрээнд дотоод хяналт тавьж ажиллаагүй байна.

- 3.1 ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон аймгийн дотоод аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.
- 3.2 ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу хүргүүлж, тайланд дүн шинжилгээ хийсэн мэдээлэл байхгүй байна.
- 3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ТАХ-ний санхүүжилтийн мэдээллийг ил тод мэдээллийн самбарт нийтэлсэн ч, ОНХНСистем болон шилэн дансанд байршуулсан мэдээлэл хугацаа хоцорсон байна
- 3.4 Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.
- 3.5 Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага бүрэн биелэсэн байна.

Зорилт 4. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд хэвийн ашиглагдаж байгаа ч зарим ТАХ-ний урсгал зардлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

- 4.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-үүдийн 80-90 хүртлэх хувийг бүрэн ашиглаж байна.
- 4.2 Нийтийн эзэмшлийн бүтээн байгуулалтад тавих хяналт сул байна. .
- 4.3 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага зөвлөмжийг 90.4 хувийн биелэлттэй байна.

Дүгнэлт, Зөвлөмж, Уламжлах санал
Тайлан баталгаажуулсан тушаал
Холбогдох байгууллагын санал
Хавсралт судалгаа
Төлбөр зөрчлийн нэгтгэл

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн хурал
БЗД	Багийн засаг дарга
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХА	Харьцуулалтын арга
ХТШ	Харьцуулсан тендер шалгаруулалт
ХБХОТХ	Хөгжлийн бодлого хөрөнгө оруулалт төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТХЗ	Техник хяналтын зардал
УИХ	Улсын их хурал
ШГ	Шууд гэрээ
ШХА	Шууд худалдан авах

АУДИТЫН НЭР: “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ”

АУДИТЫН КОД: ҮАГ-НАГ/2017/НА-01

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ

2016 оны ОНХСангийн хөрөнгийн төлөвлөлт зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулах холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг ҮАГ болон аймгийн ИТХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

ДЭД ЗОРИЛТ

-  ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
-  ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх;
-  ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх;
-  ОНХСангийн хөрөнгөөр санхүүжүүлж хийгдсэн төсөл хөтөлбөр бүрэн ашиглагдаж байгаа эсэх, өмнөх аудитаар өгөгдсөн аудитын шийдвэрүүдийн хэрэгжилтийн байдал, үр дүн;

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитаар 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтыг аймаг сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, ХБХОТХ, ГХБХБГ, багийн Засаг дарга, ИНХ ыг хамруулж, хэрэгжүүлсэн хөтөлбөр, ТАХ, түүний гүйцэтгэлийг газар дээр нь бодит байдалтай тулган шалгаж, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзлээ.

АУДИТЫН АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХУГАЦАА

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журам, арга зүйг ашиглаж аудитын дүн, дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газар, холбогдох яам, агентлаг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр, журмууд, аймгийн Засаг даргын шийдвэрүүдийг шалгуур болгон ашиглав.

Аудитыг аймгийн Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр удирдаж аудитын менежер Т.Байгалмаа үе шатны хяналтыг хийж шинжээч Г.Цог-Эрдэнэ, Х.Алтанчимэг нар гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДАХ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалтын талаар I бүлэгт, Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын талаар II бүлэгт, ОНХС-гийн зарцуулалтанд тавих хяналтын талаар III бүлэгт, ОНХСангийн хөрөнгөөр санхүүжүүлж хийгдсэн төсөл хөтөлбөр бүрэн ашиглагдаж байгаа эсэх талаар IV бүлэгт тусган аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн бүтэцтэйгээр тайлагналаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд "Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ" гэж заасан байна.

2016 оны орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг аймгийн ИТХ-ын 2015 оны 12 сарын 04- ны өдрийн “ Аймгийн 2016 оны төсөв батлах тухай “ 09 тоот тогтоолоор сумдын ОНХСангийн хөрөнгийн хэмжээг 2,547.0 сая төгрөгөөр, аймгийн ОНХСангийн хөрөнгийн хэмжээг 1,698.1 сая төгрөгөөр бүгд 4,245.1 сая төгрөгөөр баталжээ.

Монгол улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 47 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 34.2.1, 65.1.1 дэх заалтуудын дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны 09 сарын 30-ны өдрийн 05 тоот тогтоолоор 2016 оны төсвийг тодотгож баталсан байна.

Үүнд Улсын төсвийн тодотголоор орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг буурч ирсэнтэй холбоотойгоор Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд авах орлогын шилжүүлгийг **3,179.9** сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэрээс **237.5** сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл **362.1** сая төгрөг нийт **3,779.5** сая төгрөгийн эх үүсвэрийг зарцуулахаар баталснаас сумдад **2,103.3** сая төгрөгийн санхүүжилт, аймгийн ОНХС **1,402.1** сая төгрөгийг нийт **3,505.4** сая төгрөгийг олгожээ.

ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, сумдад нийт **197** төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас 73.4 хувь буюу **145** төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 18.8 хувь буюу **37** төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, 7.6 хувь буюу **15** төсөл арга хэмжээний санхүүжилт дутуу буюу он дамжин хэрэгжих шатандаа байна.

Тайлангийн жилийн эцэст аймгийн хэмжээнд ОНХСангийн бодит үлдэгдэл буюу мөнгөн хөрөнгийн дансан дахь үлдэгдэл **638.3** сая төгрөг байна. Үүний **12.3** сая төгрөг нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн, **626.0** сая төгрөг нь сумдын орон нутгийн хөгжлийн сангийн дансан дахь үлдэгдэл байна.

АУДИТЫН ЯВЦАД ТОХИОЛДСОН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Аудитын явцад аймгийн ХБХОТХ-ийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн солигдсоноос ОНХСангийн хөрөнгийн төлөвлөлт, хяналт, зарцуулалт, тайлагналтай холбоотой, нэгдсэн мэдээлэл, баримт материалыг шаардсан хугацаанд ирүүлэхгүй байх, ирсэн нь шаардлага хангахгүй байснаас гадна ОНХС-ийн зарцуулалтанд хийсэн дүн шижилгээний тайланг ирүүлээгүй/ зэргээс аудитын хөтөлбөрийн хугацаа алдагдахад хүргэж байлаа.

БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу төлөвлөж, сумдад олгох шилжүүлгийг бүрэн олгосон байна

1.1 Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг Засгийн газрын 2012 оны 09 сарын 15-ны өдрийн “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу тооцдог бөгөөд Аймгийн ИТХ-ын 2015 оны 12-р сарын 04-ны өдрийн 09 тоот тогтоол мөн 2016 оны 12-р сарын 04-ний өдрийн 06 тоот төсөв тодотгосон тогтоолоор ОНХСангийн хэмжээг 3,779.5 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд :

1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлого буюу “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-гаас олгох шилжүүлгийг **3,179.9** сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 59.1-д заасны дагуу ОНХНСангаас аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцсон байна. Үүнд:

/Хүснэгт-1/

АЙМГИЙН НЭР	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГААС ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙН ДҮН САЯ.ТӨГ/				УЛСЫН ТӨСВӨӨС ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ /САЯ.ТӨГ/			
	Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалт	Аймгаас төвлөрөх орлого	Дотоодын НӨАТ- 10%	Газрын тосны нөөц ашигласны төлбөр /5 хувь/	АМНАТ хуваарилалт /5хувь/	АМНАТ Мега төсөл /30 хувь/	Ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл	Аймаг нийслэлийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг ийн дүн
0	1=2+3+4	2	3	4	5	6	7	8=1+5+6+ 7
АРХАНГ АЙ	2650.7	680.4	1761.9	208.4	343.2	6.2	179.9	3,179.9

Дээрх тооцоолол нь ОНХНС-аас аймагт хуваарилж байгаа орлогын шилжүүлэг бөгөөд эх үүсвэрийг хуульд заасан нэр төрөл тус бүрээр төлөвлөсөн.

2. 2016 онд Аймгийн ИТХ-аас орон нутгийнхаа онцлог байдалтай уялдуулан зарим татварын хувь хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлэн ОНХСанд **237.5** сая төгрөгөөр төлөвлөжээ. Үүнд.

- Үл хөдлөх эд хөрөнгийн орлогын албан татварыг 20.0 сая төгрөгөөр
- Улсын тэмдэгтийн хураамж 30.0 сая төгрөгөөр

- Газрын төлбөрийн орлогыг 3.0 сая төгрөгөөр
 - Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 64.5 сая төгрөгөөр
 - Ус рашаан ашигласны төлбөрийн орлогыг 20.0 сая төгрөгөөр
 - Бусад орлогыг 100.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.
3. Өмнөх оны үлдэгдэл **362.1** сая төгрөгийг 2016 оны ОНХСангийн хуваарилалтанд оруулан төлөвлөсөн байна.

1.2. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөжээ

Аймгийн ИТХ-ын 2016 оны 06 дугаар тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг 3,505.4 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2103.2 сая төгрөг буюу 60 хувийг, аймгийн хөгжлийн санд 1402.2 сая төгрөгөөр буюу 40 хувийг олгохоор тооцсон байна. Энэ нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” Засгийн газрын 2012 оны 30-р тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын 9 дүгээр зүйлийн 9.2¹-т заасан 60/40 тэнцвэрт харьцаа, 3 дугаар зүйлийн 3.2-т заасан орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал алслалт, нутаг хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачлага зэрэг орлогын шилжүүлгийг тооцохдоо нөлөөлөх байдлыг харгалзан тогтоосон зарчим, аргачлал, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 6 дахь заалтын дагуу тус тус тооцож төлөвлөсөн байна.

1.3. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн санд 2016 онд, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас **3,179.9** сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэрээс **237.5** сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл **362.1** сая төгрөг нийт **3,779.5** сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

1.4. Аймгийн ОНХС-аас сумдад олгосон шилжүүлгийг хууль журмын дагуу хуваарилж батлагдсан хуваарийн дагуу олгожээ.

Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг

¹ 9.2. Аймаг нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилахад энэ аргачлалын 3 дугаар зүйлд заасан мэдээллийг ашиглан мөн аргачлалын 4-8 дугаар зүйлд заасан итгэлцүүрүүдийг орон нутгийн үзүүлэлтэд дүйцүүлэн тогтооно.

хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.2², 59.3³-т заасны дагуу дараах байдлаар тооцож хуваарилсан байна. Үүнд:

1. Сумын хүн амын тооны индекс
2. Хүн амын алслалт, нутаг дэвсгэрийн нягтралын индекс
3. Татварын идэвх санаачилгын индекс гэсэн үзүүлэлтүүдээр сумдад олгох орлогын шилжүүлгийг 60 хувиар тооцсон ба орон нутгийн хөгжлийн индексийг тооцолгүй, үлдэх 3-н итгэлцүүрт тэнцүү байдлаар буюу 33.3 хувиар тус тус байхаар тооцсны дагуу аймаг сумын ИТХ-аар төлөвлөн баталж, сар улирлын хуваарийг баталсан байна.

Аймгийн ОНХСангаас сумдад хуваарилсан ОНХСангийн орлогын шилжүүлэг

/Хүснэгт-2 /

	Сумд	Хүн амын тоо	Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ	Татварын идэвхи санаачлагаас хамааруулан олгох дүн	Итгэлцүүрт хуваарилсан дүн / сая.төг/
1	Ихамир	5433	37.50	37.9	116.7
2	Чулуут	3800	45.80	36.4	111.1
3	Хангай	3185	63.40	37.2	124.8
4	Тариат	5028	42.20	36	116.4
5	Өндөр-улаан	5764	42.90	37.1	123.7
6	Эрдэнэмандал	5535	40.30	36.8	119.1
7	Жаргалант	4359	44.80	36.8	114.8
8	Цэцэрлэг	3816	42.60	36.5	108.1
9	Хайрхан	3787	38.80	39.1	106.8
10	Батцэнгэл	3660	37.50	36.7	102.1
11	Өлзийт	3276	28.90	36.0	89.8
12	Өгийнуур	3049	25.90	36.7	85.8
13	Хашаат	3294	40.30	38.6	104.0
14	Хотонт	4371	28.10	36	97.3
15	Цэнхэр	5505	25.90	36.3	104.0
16	Төвшрүүлэх	3009	15.70	36.6	75.2
17	Булган	2510	37.80	35.8	92.7
18	Эрдэнэбулган	20718	0.75	38.9	196.1
19	Цахир	2352	61.60	34.9	114.5
20	Аймаг				1402.1
		92451	701.1	701.1	3505.4

Дээрхи үзүүлэлтийн дагуу ОНХСангаас аймгийн 19-н суманд **2103.3** сая төгрөгийг, аймгийн ОНХСанд **1,402.1** сая төгрөг нийт **3,505.4** сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

Аймгийн ОНХСангаас сумдад хуваарилан олгосон орлогын шилжүүлгийн судалгаа

/Хүснэгт-3 /

№	Сумд	Орлогын төлөвлөгөө /сая.төг/	Орлогын шилжүүлэг /сая.төг/	№	Сумд	Орлогын төлөвлөгөө /сая.төг/	Орлогын шилжүүлэг /сая.төг/
1	Ихамир	116.7	116.7	11	Өлзийт	89.9	89.9

² “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд

³ Орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, Орон нутгийн татварын идэвхи санаачлага гэсэн үзүүлэлтийг харгалзан хуваарилна

2	Чулуут	111.1	111.1	12	Өгийнуур	85.8	85.8
3	Хангай	124.8	124.8	13	Хашаат	104.0	104.0
4	Тариат	116.4	116.4	14	Хотонт	97.3	97.3
5	Өндөр-улаан	123.7	123.7	15	Цэнхэр	104.0	104.0
6	Эрдэнэмандал	119.2	119.2	16	Төвшрүүлэх	75.3	75.3
7	Жаргалант	114.7	114.7	17	Булган	92.7	92.7
8	Цэцэрлэг	108.1	108.1	18	Эрдэнэбулган	114.5	114.5
9	Хайрхан	106.7	106.7	19	Цахир	196.3	196.3
10	Батцэнгэл	102.1	102.1	Сумын дүн		2,103.3	2,103.3
				20	Аймаг	1,402.1	1,402.1
НИЙТ ДҮН						3,505.4	3,505.4

БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд захиалагчийн зүгээс бүрэн хяналт тавьж ажиллаж чадахгүй байна.

2.1. ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтыг аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2016 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл сумдын Засаг даргын мөрийн хөтөлбөр, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөжээ.

Энэ нь Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 3 зүйлийн 3.5-д “Засаг даргын тамгын газар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тухайн шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар үндэслэл, иргэдийн хурлаас гарсан санал, тэдгээрийг тусгасан байдал гэсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана” гэж заалттай нийцэж байна.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлж, иргэдийн санал авсан ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5⁴, 6.5.6⁵, 63⁶ дугаар зүйлийн 63.1, 63.2, 63.3, 63.4 дэх заалтын дагуу аймгийн 18 сумд ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр дараагийн жилд хийгдэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг иргэдийн саналыг авч багийн ИНХ-аас эрэмбэлсэн жагсаалтыг ЗДТГазарт нэгтгэн сумын ИТХ-аар хэлэлцүүлэн төлөвлөн баталж байна. Харин Эрдэнэбулган сум ОНХС-аар нийт 255.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ-г санхүүжүүлэхээр ИТХ-

⁴ 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх

⁵ 6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх.

⁶ 63 дугаар зүйл.Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах

аар баталсан. Гэвч дээрх 10 ТАХ нь 2014 онд иргэдээс санал авч эрэмбэлсэн ажлууд байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн, 60.3.6⁷ дахь заалтыг биелүүлээгүй гэж үзэхээр байна.

Аймгийн хувьд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтыг Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлтэй уялдуулан ач холбогдолтой гэж үзсэн 6 ТАХ-г ИТХ-аар батлуулсан байна. Аудитын явцад аймгийн иргэдээс санал авч хэлэлцүүлсэн баримт материал шалгагдаагүй болно.

Аймгийн хэмжээний 19 сумдаас түүврийн аргаар 12 сумын 356 иргэдээс ОНХС-аас хэрэгжүүлсэн ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлдэг эсэх талаар санал асуулга авч нэгтгэлээ.

Судалгаанд оролцогчдыг хүйсээр болон Боловсролын түвшингээр ангилахад дараах байдалтай байна.

/График-1/



Судалгааны асуулт-1 /График-2/



ОНХС-гийн санхүүжилтийн ямар төсөл арга хэмжээ танай суманд хэрэгжиж буй талаар та хэр мэдээлэлтэй байна вэ? гэсэн асуултанд нийт оролцогчдын 50.5% “сайн мэднэ” гэж хариулсан нь ТАХ иргэдэд нээлттэй, ил тод байгааг харуулж байна.


⁷ 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

Судалгааны асуулт-2 /График-3/




ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх БИНХ-д та оролцож байсан уу? гэсэн асуултанд нийт оролцогчдын 39.3% нь “хааяа”, 38.2% нь “байнга оролцдог” гэж хариулснаас харахад БИНХ-д иргэдийн оролцоо боломжийн байгааг харуулж байна.

Судалгаа асуулт-3 /График-4/




Хэрэв оролцож байсан бол зарим шаардлагатай асуудлыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар таны бодол? гэсэн асуултанд нийт оролцогчдын 33.7% нь “оролцогч иргэдээс санал авч хэлэлцүүлдэг” гэж хариулснаас харахад Иргэд өөрсдийн санал авч дэвшүүлсэн ажлаа ОНХС-аар хөрөнгөөр гүйцэтгүүлж чаддаг гэж үзэхээр байна.

Судалгааны асуулт-4 /График-5/



ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг уу? гэсэн асуултанд нийт иргэдийн 59.5% нь тийм гэж хариулсан нь ТАХ-ны мэдээллийг иргэдэд нээлттэй ил тод байршуулдаг гэж үзэхээр байна.

Судалгааны асуулт-5 /График-6/



ОНХС-аас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас танай өрхөд ирж байсан уу? гэсэн асуултанд 70.7% нь саналын хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл өгдөг гэж хариулсныг харахад БИНХ-д иргэдийг хамруулахад түлхүү анхаардаг

гэж гэж үзэхээр байна.

Дээрх санал асуулгыг нэгтгэхэд ОНХС-аар хэрэгжүүлдэг ТАХ-үүдийг БИНХ-аар хэлэлцүүлж, иргэдээс санал авч эрэмбэлж, тухайн сум орон нутагт нэн шаардлагатай төсөл арга хэмжээг санхүүжүүлж, иргэдэд энэ талаарх мэдээллийг нээлттэй ил тод мэдээллэдэг гэж үзэхэд хүргэлээ

2.3. ТЭЗҮ, зураг төсөвгүй ажилд хөрөнгө зарцуулах нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.7-д “Хөрөнгө оруулалт хөтөлбөр, ТАХ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” гэж заасны дагуу аймаг 2016 оны ОНХСангийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн ажлуудын жагсаалтад ТЭЗҮ, зураг төсөвт нийт өртгийн 6.7% буюу 94.6 сая төгрөг батлагдаж 100% зарцуулагдсан боловч өмнөх онтой харьцуулахад 3.9%-иар буурсан байна.

Зарим сумдын хувьд 2016 оны ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилж гаргаагүй, зарим ажлыг тайлант хугацаанд зураг төсвийг гаргуулан гүйцэтгэсэн боловч эрх бүхий байгууллагаар баталгаажуулаагүй байгаа нь Орон нутгийн хөгжлийн зааврын 4.7 дахь заалттай нийцэхгүй байна. Үүнд:

- ✓ Өндөр-улаан суманд 48.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв талбайн хайс, машины зогсоолын ажил”-ыг гүйцэтгүүлэхээр “Тамирын Цахиур” ХХК–тай гэрээ байгуулсан ч захиалагч байгууллагаас техникийн тодорхойлолт гаргаагүй, ажлын гүйцэтгэлийн явц хэдэн хувьтай байгаа нь тодорхойгүй байхад 24.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- ✓ Цахир суманд 69.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Баянгол багт үүрэн холбооны барилга цамхаг”-ын ажлыг гүйцэтгүүлэхээр Мянган Өндөр Цахир ХХК -тай гэрээ байгуулсан ч газрын байрлал, барилгын зураг, техникийн тодорхойлолтыг захиалагчийн шийдвэргүйгээр өөрчилсөн, ажлын гүйцэтгэлийн явц хэдэн хувьтай байгаа нь тодорхойгүй байхад 49.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- ✓ Эрдэнэбулган суманд хувьд 3 болон 7-р багийн төвийн БУА-г зохион явуулахдаа газрын асуудлыг шийдвэрлээгүйн улмаас шалгарсан компани ажлыг эхлүүлэлгүй он дамжсан асуудал үүссэн нь дээрх 4.7 дахь заалтыг зөрчсөн байна.

2.4 Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн зарим заалтыг биелүүлэхгүй байна.


2016 онд аймаг, сумын ОНХС-д өмнөх оноос шилжин ирсэн 1638.4 сая төгрөгийн 48 ажил, 2905.7 сая төгрөгийн 154 ажлыг шинээр хэрэгжүүлж, санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдаж ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Тайлант онд 876.3 сая төгрөгийн 8 ажилд нээлттэй тендер, 1257.0 сая төгрөгийн 52 ажилд харьцуулалтын арга, 452.6 сая төгрөгийн 65 ажилд шууд гэрээ байгуулагдаж, 319.8 сая төгрөгийн 29 ажлын ХАА-г зохион байгуулаагүй байна.

/Хавсралт судалгаа-3/

Аймаг, сумдын хэмжээнд зохион байгуулсан ТАХ-г графикаар харуулбал:

/График-7/



Үүнээс аймагт НТШ-аар 200.0 сая төгрөгийн 2 ТАХ-г, харьцуулалтын аргаар 92.5 сая төгрөгийн 3 ТАХ-г, ШГБ-аар 109.6 сая төгрөгийн 2 ТАХ-г зохион байгуулсан байна.

Аймаг сумдын ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр 2016 онд хийгдсэн ажлуудын тендерийн урилгыг “Төрийн болон орн нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу цаг тухай бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж “Архангайн амьдрал”, “Архангайн толь” зэрэг сонинд нийтэлж, цахим хуудас болон Сангийн яамны “e-procurement.mof.gov.mn”, аймгийн Худалдан авах ажиллагааны албаны procurement.to.gov.mn сайт, байгууллагын мэдээ, мэдээллийн самбар, иргэний танхим дахь худалдан авах ажиллагааны албаны самбарт тус тус байршуулан тендерт оролцохыг сонирхогчдод тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор ханган мэдээллийг ил тод нээлттэй тавьж ажилласан байна.

Өлзийт сум ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн 223.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цэвэр усны инженерийн шугам сүлжээ, Даралтат цамхагийн ажил”-ын худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТХуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн зөрчил илэрсэн. Үүнд:

- Уг төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримтнаас үзэхэд Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу нээлттэй тендер зарлаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэх ёстой байтал 3 компанид урилга хүргүүлж, харьцуулалтын аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 7.2 дахь заалтыг зөрчсөн.
- Тендерийн урилга хүлээн авсан 3 компаниас зөвхөн 1 компани буюу Долоон бар ХХК 250.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр үнийн санал ирүүлсэн нь төсөвт өртөгөөс 12% буюу 26.2 сая төгрөгөөр хэтэрсэн байхад үнэлгээний хороо хамгийн сайн шалгарсан тендер гэж үзэн гэрээ байгуулах зөвлөмжийг Засаг даргад хүргүүлсэн нь ТБОНӨТБАҮХАТХуулийн 30.1.3⁸ -дахь заалтыг зөрчсөн байна.
- Үнэлгээний хорооны зөвлөмж 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр ирсэн байхад Захиалагч тал гүйцэтгэгч компанитай 30 хоногийн дараа буюу 2016 оны 11 сарын 21-ны өдөр гэрээ байгуулсан нь ТБОНӨТБАҮХАТХуулийн 29.2.⁹ дахь заалтыг зөрчсөн байна.
- Үнэлгээний хорооны гишүүд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт маягт буюу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх тухай мэдэгдэл гаргаагүй зэрэг зөрчлийг холбогдох газарт шалгуулахаар ҮАГ-т саналыг уламжилсны дагуу Сангийн яамны хууль худалдан авах ажиллагааны газарт ХАА-ны баримтыг шилжүүллээ.

Аймгийн 19-н сумын ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ны худалдан авах ажиллагааг шалгахад ТБОНӨХБАҮХАТХуулийг мөрдөж ажиллаагүй нийтлэг зөрчлүүд илэрч байна. Үүнд: Үнэлгээний хороонд оролцогч гишүүд нь худалдан авах ажиллагаагаар мэргэшээгүй, ашиг сонирхолын зөрчилгүй мэдэгдэл гаргадаггүй, тендерийн баримт бичгийн архивын нэгж үүсгээгүй, бүрдүүлэлт хангалтгүй байна.

Дээрх нийтлэг зөрчлийг арилгах сайжруулах талаар Аймгийн ТЕЗ-д зөвлөмж хүргүүлээ .

2.5. ОНХС-ийн хөрөнгийг зарим сумдууд урсгал зардалд зарцуулахаар баталж байна.

Аймгийн хэмжээнд Сангийн сайдын 2012 оны 43-р тогтоолын дагуу ОНХС-ийн хөрөнгийг зарцуулж байгаа боловч дараах 2 сум хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад ТАХ-нд сангийн хөрөнгийг зарцуулсан гэж үзэхээр байна.

Өгийнуур сум 2014 оны ОНХСангийн хөрөнгөөр 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хогийн цэгийг хашиж, цэвэрлэх, цэгцлэх, тохижуулах”, Төвшрүүлэх сум

⁸ “ Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5%-иар хэтэрсэн тохиолдолд тендерээс татгалзана”

⁹ “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.”

2015 оны ОНХСангийн хөрөнгөөр 27.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хогийн төвлөрсөн цэг байгуулах” төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн нь СС-ын 43-р тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4.1 /з/-д “хогийн төвлөрсөн цэг байгуулах, хог боловсруулах жижиг хэмжээний үйлвэр байгуулах” гэсэн заалтын дагуу төлөвлөн баталж гүйцэтгэсэн байна. Гэтэл хөтөлбөрийн хүрээнд уг ТАХ-ний ашиглалт, хамгаалалттай холбоотой **урсгал** зардлыг 2016 оны ОНХСангийн хөрөнгөөс санхүүжилсэн байна. Тухайлбал: Төвшрүүлэх суманд 2016 оны ОНХСангийн хөрөнгөөр “Хог хөтөлбөр” арга хэмжээнд 2.5 сая төгрөг, Өгийнуур суманд 2016 оны ОНХСангийн хөрөнгөөр “Хог хаягдлын менемжентийг сайжруулах” хөтөлбөрт 8.0 сая төгрөгийг баталж хэрэгжүүлсэн байна. Дээрхи хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримтаар шалгахад цалин, шимтгэл, бензин шатахуун г.м урсгал зардалд зарцуулагдсан байлаа. Ингэж хөтөлбөр нэрээр урсгал зардлыг сангийн хөрөнгөөр шийдэж байгаа нь **Төсвийн тухай хуулийн 60.3.1-д** “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”, СС-ын 43-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4.1 /з/¹⁰, 4.3¹¹, 4.4¹².дэх заалттай тус тус нийцэхгүй байна. Аудитын зүгээс СС-ын 43-р тушаалын 4.3, 4.4 дүгээр заалтыг нэг мөр ойлгох хэмжээнд болгох үүднээс ҮАГ-ийн нийцлийн аудитын газарт уламжлан санал авч дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлээ.

2.6. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг бүрэн тавьж чадахгүй, ажлын гүйцэтгэл тодорхойгүй байхад санхүүжилтийг олгосоор байна.

2016 онд ОНХС-аар нийт 3524.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 160 ТАХ-г санхүүжүүлэхээр гэрээ байгуулснаас нийт ТАХ-ний 78.2 хувь буюу 3011.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 145 ТАХ бүрэн хэрэгжиж хүлээн авсан бөгөөд 4.2 хувь буюу 149.8 сая төгрөгийн 16 ТАХ-ний санхүүжилтийг дутуу олгосон байна. Харин 15 ТАХ-г дутуу хэрэгжүүлж 37 ТАХ-г огт хэрэгжүүлээгүй байна.

/Хавсралт судалгаа-2/

Аймаг, сумдад ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудыг иргэд өөрсдөө төлөвлөж санаачлан хэрэгжүүлснээр нэн тэргүүнд хэрэгцээт ажлуудыг амжилттай хэрэгжүүлж бүтээн байгуулалтын ажил хийгдэж, сум орон нутгийнхаа өнгийг зассан нүдэнд харагдах бодит үр дүнтэй ажлууд бий болсон байна. Үүнд:

- ✓ Хотонт суманд Бургалтай, Хөөвөр, Улаан-чулуу багуудад 37.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багийн төвийн засварын ажил, 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сумын төвийн гэрэлтүүлэг, 4 багт 29.5 сая

¹⁰ Хогийн төвлөрсөн цэг байгуулах, хог боловсруулах жижиг хэмжээний үйлдвэр байгуулах

¹¹ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх

¹² Аймаг, сумын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх

төгрөгийн төсөвт өртөгтэй гүний өрөмдлөгтэй 4 цооногийн ажлыг хийж гүйцэтгэхдээ захиалагчийн зүгээс хяналтыг тогтмол хэрэгжүүлсний үр дүнд 100% ашиглагдаж, ашиглагчийн зүгээс ямар нэгэн санал гомдол байхгүй байна.



/Багийн төвийн засвар/



/Гүний өрөмдлөгтэй цооног/

- ✓ Цэнхэр сум цэнхэр багийн төвд 48.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй өвсний фондны хашаа, өвс хураах саравч, агуулахын байр барих ажлыг чанартай сайн хийж гүйцэтгэсэн нь малчдын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан, иргэдийн сэтгэлд нийцсэн ажил болсон байна.



/ Өвсний фондны хашаа, өвс хураах саравч/

Нийт хэрэгжүүлсэн ажлуудын 73.4 хувийг бүрэн хэрэгжүүлж хүлээн авч бүртгэлд тайланд тусган, ашиглаж байгаа боловч зарим хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл хангалтгүй байхад санхүүжилтийг олгож, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулжээ. Үүнд:

- ✓ Өндөр-улаан сум 46.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Азарга, Донгой, Бэлхи, Баянгол багуудад инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг БИММ ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ч захиалагчийн хяналт хийгдээгүй, ажлын гүйцэтгэлд гүйцэтгэлийн баталгаа гараагүй байхад **13.9** сая төгрөгийн санхүүжилт олгосон;
- ✓ Хангай сум: 2015, 2016 оны ОНХСангийн хөрөнгөөр он дамжин гүйцэтгэсэн 9.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүндэтгэлийн гэрийн засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Дээдсийн гэр ХХК -тай гэрээ байгуулсан боловч тус ажилд захиалагчийн хяналт хийгдээгүй, ажлын гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй байхад санхүүжилтийг 100% олгосон, мөн хүндэтгэлийн гэрийн хуучин дээвэр, туурга

бусад холбогдох хөрөнгийг гүйцэтгэгч байгууллагад зөвшөөрөлгүй шилжүүлсэн байна.

Хангай сум 2015 онд **112.6 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй шороон хучилттай авто зам тавих ажлыг гүйцэтгүүлэхээр Зургаадай зам ХХК-тай гэрээ байгуулсан. Гэтэл гэрээт хугацаанд ажлыг гүйцэтгээгүй, он дамжсан, гүйцэтгэсэн ажлын календарчилсан төлөвлөгөө, ажлын гүйцэтгэлгүй, ажлын гүйцэтгэлийн явц хэдэн хувьтай байгаа нь тодорхойгүй мөн ажлын даалгаварт тусгагдсан ажлыг чанар муутай дутуу гүйцэтгэсэн байхад санхүүжилтийг 100% олгосон байна. Энэхүү ажлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналыг аудитаас гаргаж *ҮАГ-т холбогдох баримт материалыг шилжүүлсний дагуу аудитын зүгээс захиалагч талыг гэрээний үүргийн дагуу хуулийн байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлээ.*



/Шороон хучилттай авто зам,явган хүний зам/

- ✓ Тариат сум 5.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ахуйн үйлчилгээний төвийн тохижилтын ажил, 2.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хорго багийн конторын халаалт, 1.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цагдаагийн тасгийн мотоцикль, 5.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ гэсэн 4 ТАХ-ний ажлын гүйцэтгэлд гүйцэтгэлийн баталгаа гаргаагүй, гэрээг дүгнээгүй байхад нийт **16.0** сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- ✓ Чулуут сум 32.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хогийн төвлөрсөн цэг байгуулах ажилд захиалагчийн хяналт хийгдээгүй, ажлын гүйцэтгэлд гүйцэтгэлийн баталгаа гаргаагүй, гэрээт хугацаанд ажлыг гүйцэтгээгүй, он дамжсан, гэрээний хугацааг сунгаагүй байхад 9.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Мөн Өлзийт гол багийн улаан эргийн гарамд 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 45м урттай, 3.9 м өргөн **гүүр барих ажлын** гүйцэтгэгчээр Д.Бямбажаргалтай гэрээ байгуулж 6.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй, гэрээт хугацаанд ажлыг гүйцэтгээгүй, он дамжсан, гэрээний хугацааг сунгаагүй.
- ✓ Өгийнуур сум 49.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өгийнуурыг хашиж

хамгаалах, аялагч амрагчдын түр байрших цэгийн тохижилт хийх ажлын гүйцэтгэлд захиалагч байгууллагаас хяналт хийгдээгүй, гэрээт хугацаанд ажлыг дуусгаагүй, гэрээ сунгалт хийгдээгүй байхад нийт санхүүжилтийн 70.9 хувь буюу **35.0** сая төгрөгийг олгосон.



/Өгийнуурыг хашиж хамгаалах, аялагч амрагчдын түр байрших цэгийн тохижилт/

- ✓ Хашаат сум 7.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй мал угаалгын ванн, тарилгын хашаа барих, 34.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Жаргалант багийн шанд, Номгон багийн бор хоолойд шинээр худаг гаргах ажлуудад захиалагчийн хяналт хийгдээгүй, ажлын гүйцэтгэлд гүйцэтгэлийн баталгаа гаргаагүй байхад **41.0** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
- ✓ Төвшрүүлэх сум 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Худаг ус гүний өрмийн 2 цооног гаргах ажлын гүйцэтгэгчээр Бимм ХХК-тай гэрээ байгуулсан ч гэрээт хугацаанд ажлыг дуусгаагүй, он дамжсан, гэрээний хугацааг сунгаагүй ажил хэзээ эхлэх нь тодорхойгүй ажилд **10.0** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
- ✓ Эрдэнэмандал сум 7.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төв замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Голомт констракшн ХХК-тай гэрээ байгуулж ажилласан боловч мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгээгүй, ажлын гүйцэтгэл муу, чанаргүй хийгдсэн байна.



/Төв замын арчлалт, засварын ажил/

- ✓ Хайрхан сум 54.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дулааны шугам, 0.4 квт агаарын шугам татах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн боловч ажлыг хүлээн авахдаа тогтоосон гэрээт хугацаанаас 5 сарын дараа хүлээн авсан бөгөөд гэрээнд хариуцлагын талаарх

заалтыг тусгаж өгөөгүйгээс алданги тооцох боломжгүй, мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт хийлгээгүй.

- ✓ Цэцэрлэг сум 25.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий сумын төвийн гэрэлтүүлэг, тохижилтын ажлыг зохион байгуулахдаа техникийн даалгавар болон ажлын гүйцэтгэл өөр байхад ажлыг хүлээн авсан, ажлын явцад захиалагчийн хяналт тавиагүй байна.
- ✓ Эрдэнэбулган сум 84.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3-р багийн төвийн БУА гүйцэтгүүлэхээр РИЦА ХХК-тй, 89.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7-р багийн төвийн БУА-г гүйцэтгүүлэхээр Евро ази ХХК-тай тус тус гэрээ байгуулан нийт **77.4** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Ажлын гүйцэтгэлийг газар дээр нь очиж шалгахад 3-р багийн төв 30 хувийн гүйцэтгэлтэй, 7-р багийн төвийн БУА эхлээгүй байдалтай байна. Дээрх 2 ТАХ-нд мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгээгүйгээс БУА удаашрах, ажлын бодит гүйцэтгэлийг гаргах боломжгүй байна.



/7-р багийн БУА нийт санхүүжилтийн
30%-ийг авсан ажлын гүйцэтгэл 0%-тай/



/3-р багийн БУА нийт санхүүжилтийн
70%-ийг авсан ажлын гүйцэтгэл 30%-тай/

Аудитын явцад илэрсэн дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

ОНХСангийн хөрөнгөөр орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудад захиалагчийн хяналтыг Мэргэжлийн байгууллагаар тавиулах шаардлагатай байна. Ингэснээр хөрөнгийн ашиглалт сайжирч, ажлын гүйцэтгэл чанартай хийгдэхээр байна. Иймд аудитаас СС-ын 43-р тушаалд захиалагчийн хяналтыг **мэргэжлийн байгууллагаар** хэрэгжүүлж ажиллах талаарх заалтыг нэмж тусгуулах саналыг ҮАГ-т уламжилж байна.

2.7. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн дагуу бүртгэл тайланд тусгасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг бүртгэлд тусгах ажлыг төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад дүрэм журмын дагуу 2016 онд 87 ТАХ-ний 2,053.9 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгасан байна. Нийт хөрөнгийн 1,390.8 сая төгрөг буюу 67.7 хувь нь Орон нутгийн салбарт, 565.5 сая төгрөг буюу 27.5 хувь нь боловсролын салбарт, 94.1 сая төгрөг буюу 4.5 хувь нь соёлын салбарт, 3.5 сая төгрөг буюу 0.1 хувь нь эрүүл мэндийн салбарт тус тус бүртгэгджээ.

/ОНӨА-аас ирүүлсэн судалгаанаас/

Өмнөх онуудтай харьцуулахад бүртгэл тайланд тусгахгүй орхигдуулдаг зөрчил энэ онд багассан боловч аудитын явцад ОНХСангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бараа ажил үйлчилгээг санхүүгийн тайлангийн данс бүртгэлд бүрэн тусгах ажлыг хууль, дүрмийн дагуу хийж гүйцэтгээгүй зарим зөрчил байгааг дурдвал:

- Булган сумын ЗДТГазар 19.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Хүндэтгэлийн хаалга барих ажил, 18.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэрэлтүүлгийн ажил,
- Өлзийт сум 3.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Цагдаагийн байрны засварын ажлыг бүртгэлд тусгаагүй нь Сангийн сайдын 290-р тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, тайлагналын журам”-ын 5.1 ¹³-дахь заалтыг зөрчсөн тул дээрх 2 суманд хөрөнгийг бүртгэл тайланд тусган хариу ирүүлэх албан шаардлага хүргүүлээ.

БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн байдалд хууль, журмын хүрээнд дотоод хяналт тавьж ажиллаагүй байна

3.1 ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон аймгийн дотоод аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

2016 оны аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд хэрэгжүүлсэн хяналтын талаарх тайлан мэдээ, судалгааг гаргаж ирүүлэхийг албан тоотоор уламжилсан боловч тухайн онд аймгийн ИТХ болон СХДАА-аас ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй гэсэн хариу ирүүлсэн.

/ИТХ-ын 2016 оны 03 сарын 14 өдрийн 73, СХДАА-ны 03 сарын 13 өдрийн 29 албан тоотууд/

Сумдын хувьд сумын Засаг даргын шийдвэрээр ИТХ-аас сонгогдсон ажлын хэсэг болон иргэний нийгмийн байгууллагууд Сангийн сайдын 43 дугаар

¹³ “...хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэх бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр тухайн төсөвт байгууллагын тайлан балансанд бүртгэнэ”

тушаал Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 9.4¹⁴ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй,ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.

/График-8/



ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт тавьж ажиллаагүйгээс аудитын явцад 1168.6 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрлээ. Дээрх зөрчлийг өмнөх онтой харьцуулж графикаар харуулбал:

Захиалагчийн хяналт хийгдээгүй ажил өмнөх оноос 37.8 хувь буюу 187.8 сая, дутуу буюу чанаргүй хугацаа хэтэрсэн ажил 55.0 хувь буюу 116.2 сая, ХАА-ны тухай хууль зөрсөн 100 хувь буюу 228.3 сая, хэрэгжээгүй санхүүжилтээ аваад ажлаа хийж гүйцэтгээгүй 90.9 хувь буюу 70.4 сая төгрөгөөр тус тус зөрчил нэмэгдсэн байгаа нь иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, холбогдох мэргэжилтнүүдийн хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатайг харуулж байна.

3.2 ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу хүргүүлж, тайланд дүн шинжилгээ хийсэн үү?

ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1¹⁵, 10.2¹⁶ 10.3¹⁷ дахь заалтын дагуу тайланд дүн шинжилгээ хийж тайланг хүргүүлэх ёстой боловч Аудитын явцад Аймгийн ЗДТГ-ын ХБХОТХ-ээс дээрх тайлан судалгааг ирүүлээгүй тул Аудитын явцад шалгагдаагүй болно

¹⁴ Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь сайн дурын идэвхитэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран, ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

¹⁵ Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 07 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа 02 дугаар сарын 01-ны дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ХБХ-т хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах эрх бүхий ЗДТГ-ын ХБХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг ЗД-ын захирамжаар томилж ажилууллана.

¹⁶ Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн ЗД-д танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 02 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ.

¹⁷ Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайланг гарсан зөвлөмжийн хамт жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор сангийн яамны ОНХНСангийн хэлтэст ирүүлнэ.

3.3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ТАХ-ний санхүүжилтийн мэдээллийг ил тод мэдээллийн самбарт нийтлэсэн ч, ОНХНСистем болон шилэн дансанд байршуулсан мэдээлэл хугацаа хоцорсон байна.

Аймгийн хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн журам"-ын 11.2.3¹⁸-д заасны дагуу ОНХС-ийн санхүүжилтийг нийтэд ил тод мэдээллэсэн эсэхийг шалгахад бүх сумд мэдээллийн ил тод байдлын самбар ажиллуулж, самбарт орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөгөө, өмнөх оны ажлын гүйцэтгэлийг гаргаж байршуулсан байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ТАХ-ний санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангийн журам"-ын 11.4¹⁹ заалт болон Шилэн дансны тухай хуулийн 6.9²⁰ дэх заалтуудын дагуу ил тод мэдээллэсэн эсэхийг шалгахад 10 сум ОНХС-ийн санхүүжилтийг сангийн яамны сайт дахь ОНХС-ийн нэгдсэн системд мэдээллэсэн, 9 сум мэдээллээгүй байлаа. Дээрх сумдаас аудитын явцад 5 сумдын ОНХС-ийн санхүүжилтийн мэдээллийг шивүүлж залруулга хийсэн бол Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал, Жаргалант зэрэг сумдуудад санхүүжилтийн мэдээллийг бүрэн үнэн зөв, нөхөж оруулахыг шаардсан албан шаардлага хүргүүлээ.

Мөн "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай" журамд заасан байршуулбал зохих 11 мэдээллээс 1-4 мэдээллийг буюу 2016 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, 5.0 саяас дээш орлого зарлагын мөнгөн гүйлгээ, сарын мэдээ, орлогын гүйцэтгэлийн мэдээллийг байршуулсан боловч хугацаа хоцроосон байдалтай байна.

3.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Орон хөгжлийн сангийн зарцуулалтын байдалд нийцлийн аудит хийж хууль, журмын нийцлийг шалгахад дараах хууль, журмын заалтад өөрчлөлт хийх шаардлага байгаа нь ажиглагдлаа.

1. Төсвийн тухай хуулийн 58.2.17, 58.4.9 дэх заалтуудад “ хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” гэдэгт хуулийн байгууллагын тайлбар гаргах нь зүйтэй байна.

¹⁸ Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байршуулж, нийтэд тогтмол мэдээллэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж байна..

¹⁹ “... сумын төрийн сангийн төлөөлөгч ОНХС-ын хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг тухай бүр системд оруулж бүртгэнэ”

²⁰ “... орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт,... хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно”

Төсвийн тухай хуулийн 58.2.17, 58.4.9 дэх заалтуудад “ хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” гэдэгт юуг ойлгох нь тодорхой бус албан ёсны хуулийн тайлбар байхгүй байгаа нь дараах хуулийн заалт зөрчихөд хүргэж байна. Үүнд:

1. Хуулийн 6.6.6-д “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”
2. Хуулийн 60.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”,
3. Хуулийн 60.4 “Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй”
4. Хуулийн 58.4 “Сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ” гэж заасан нь сум, орон нутгийн хэмжээнд хийгдэх өөр бусад нэн шаардлагатай ажлуудыг хийхийг хязгаарласан мэт ойлголтыг өгч байна.

/2016 оны 9 сарын 9-ны өдрийн Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр дээрх асуудалд өөрчлөлт орж 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчилагдсан/

Дээрх тайлбарыг тодорхой болгосноор Сангийн яамны 2013 оны 4-1/2884/ тоот тушаалаар өгөгдсөн зөвлөмжийн 10 дахь заалт, 2014 оны 43 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4.7 зэрэг хуультай нийцээгүй, хуулиас давсан зөвлөмж, зааврыг нэг мөр ойлгоход тустай байна гэж үзэж байна.

2. Төсвийн тухай хуулийн 58.2.4, 58.4.2-т заасан тухайн шатны Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахгүй байхаар хориглосон заалт байх нь зүйтэй байна.

Үүнээс болж орон нутгийн төсөв, ОНХС-аас хөрөнгө давхардаж зарцуулагдахад хүргэж байна.

Хуулийн заалтад дээрх өөрчлөлт орсноор ОНХС-ийн хөрөнгө зорилгын дагуу зарцуулагдах болно.

3. ОНХС-тай холбоотой ТБОНӨХБАҮХАТХ, Барилгын тухай хуулиудын холбогдох заалтад өөрчлөлт оруулах шаардлага байна.

Учир нь: Барилгын тухай хуульд барилгын засварын ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөлтэй байна гэж заасан байдаг. Гэтэл сум орон нутагт ихэнхдээ бага хэмжээний барилгын засварын ажлууд 10.0-40.0 сая хүртэлх өртөгөөр хийгддэг. Үүнийг Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажилллагааны журам”-ын дагуу зохион байгуулах гэхээр Барилгын тухай хууль зөрчигддөг. Мөн хуулийн дагуу үнэлгээний хороо байгуулах нөхцөл бүрдэхгүй байна. Иймд:

3.1 ТБОНӨХБАҮХАТХ-д сум орон нутгийн тухайд босго үнээс хэтрээгүй тохиолдолд ажлын хэсэг ажиллах, ажлын хэсэг нь үнэлгээний хорооны нэгэн адил эрх эдэлнэ гэсэн заалт нэмж тусгуулах,

3.2 3.2 10.0-40.0 сая төгрөгийн өртөг бүхий барилгын болон засварын ажилд тусгай зөвшөөрөлтэй байж болно, харин аймгийн ерөнхий архитектор хянасан байна */зөвшөөрөлгүй байлаа гэхэд ерөнхий архитектор хянасан байхад ерөнхийдөө болно гэж ойлгогдоно. Энэ нь олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулалтад тохирох болно./* гэх мэт агуулга бүхий заалтыг нэмж тусгуулах шаардлага байна.

4. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 53 дугаар зүйлд худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхийн нэгжийн үүрэгтэй холбоотой заалтыг нэмж оруулах. Ингэснээр аймгийн ХААА нь арай өргөн хүрээтэй ажиллах нөхцөл бүрдэхээр байна.

3.5 Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага бүрэн биелэсэн байна.

2015 оны ОНХС-ийн аудитаар нийт 528.5 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс ТАХ дутуу буюу чанаргүй хийгдсэн, гэрээний хугацаа хэтэрсэн 94.5 сая төгрөгийн, иргэдийн саналыг авалгүй хэрэгжүүлсэн 8.0 сая төгрөгийн, хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй 108.5 сая төгрөгийн, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй 7.0 сая төгрөгийн, бусад 307.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчил дутагдлыг арилгах албан шаардлага хүргүүлснээс биелэлт 100%-тай байна.

Төлбөрийн актны хувьд 15%-ийн биелэлттэй байгаа бөгөөд 2.2 сая төгрөг хууль хяналтын байгууллагад шилжигдсэн, 2.5 төгрөгийг 2017 оны 11 сард бүрэн барагдуулах хүсэлт ирүүлсэн байна. /Хангай сумын тоот албан бичиг/

2016 оны ОНХС-ийн аудитаар нийт **1,136.5** сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс **1.8** сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоож, **1134.7** сая төгрөгөнд албан шаардлага хүргүүлж хүргүүлж, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн засаг даргад хүргүүлээ.

БҮЛЭГ 4. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд хэвийн ашиглагдаж байгаа ч зарим ТАХ-ний урсгал зардлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

4.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-үүдийн 80-90 хүртлэх хувийг бүрэн ашиглаж байна.

Аймгийн Аудитын газраас 2013-2016 онуудад аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ны хөрөнгийн үр ашиг, чанар, үр дүн, ашиглалтын байдлыг энэ удаагийн аудитаар шалган санал зөвлөмж өгөх зорилтыг дэвшүүлсэн.

2013-2016 оны байдлаарх ОНХСангийн хөрөнгөөр нийт 929 ТАХ-нд 26,388.4 сая төгрөгийг зарцуулсан байна. /Хүснэгт-4/

ОН	Хийгдсэн ажлын тоо	Олгосон санхүүжилт
2013	312	9,611.1
2014	286	8,848.8
2015	176	4,774.6
2016	160	3,153.9
НИЙТ ДҮН	929	26388.4

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн ТАХ-г сүүлийн 4 жилийн байдлаар харуулбал: /график-9/



2013-2016 оноос хэрэгжүүлсэн ТАХ-ний 28.3 хувь буюу 7471.5 сая төгрөгийг барилга байгууламж, 35.5 хувь буюу 9,375.1 сая төгрөгийг машин тоног төхөөрөмж, 26.6 хувь буюу 7,038.0 сая төгрөгийг их засварын ажил, 9.4 хувь буюу 2503.8 сая төгрөгийг хөтөлбөр төсөл арга хэмжээнд зарцуулжээ. Өмнөх онуудтай харьцуулахад машин тоног төхөөрөмж буюу үндсэн хөрөнгө худалдаж авах, их

засварын ажлууд буурч байгаа нь ОНХНС-аас ирэх орлогын шилжүүлгийн хэмжээ багассантай холбоотой боловч барилга байгууламж барих ТАХ-ний дүн буурахгүй байна. Иймд *Барилга угсралтын болон Их засварын ажлуудад зайлшгүй мэргэжлийн байгууллагыг татан оролцуулж захиалагчийн хяналтыг заавал хийлгэх шаардлагатайг харуулж байна.*

Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилт, ашиглалт, үр дүнгийн байдлыг аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэнтэй хамтран, аймгийн бүх сумдад очиж шалгахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 80-90 хүртэлх хувь нь хэвийн ашиглагдаж байгаа бөгөөд зарим ТАХ-нүүдийн урсгал зардлыг шийдвэрлээгүйгээс бүрэн ашиглагдахгүй, ашиглалтын явцад эвдэрч гэмтсэн, санхүүжилтийг урсгал зардалд зарцуулах шинж ажиглагдаж байна. Үүнд:

- ✓ Эрдэнэмандал, Цэцэрлэг сумдад 2015 оны ОНХС-ийн хөрөнгөөр Ахуйн үйлчилгээний барилгын ажлыг гүйцэтгүүлж хүлээн авсан боловч дээрхи сумдын барилгуудыг цахилгаан халаалтаар шийдсэний улмаас өвлийн нөхцөлд цахилгааны зардал өндөр гарч байгаагаас шалтгаалан түрээсийн төлбөр өндөр тогтоогдож одоогийн байдлаар түрээслэгчгүй ашиглагдаагүй байна.
- ✓ Тариат сум 2016 оны ОНХСангийн хөрөнгөөр 6.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах ажлын гүйцэтгэгчээр Эх тэнгэрийн мандал ХХК-тай гэрээ байгуулж санхүүжилтийг 100% шилжүүлсэн ч одоог хүртэл тоног төхөөрөмжийг хүлээн авч ашиглаагүй байна.
- ✓ Хашаат сум 9.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах ажлын санхүүжилтийг 100% олгосон боловч 1.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Даралтат хөгжим, Ардатар зэрэг тоног төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниас одоог хүртэл хүлээж аваагүй;
- ✓ Аймаг 2014 оны ОНХС-ийн хөрөнгөөр 635.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ахуй үйлчилгээний барилгын ажлыг “Зориг конструктор” ХХК эхлүүлсэн ч өнөөдрийг хүртэл ашиглалтанд ороогүй, 2 он дамжсан, одоогийн байдлаар гүйцэтгэл хэдэн хувьтай байгаа нь тодорхойгүй, захиалагч талаас ажлын гүйцэтгэлд бүрэн хяналт тавьж ажиллаагүй зэргээс шалтгаалан тус ажил нь одоогийн байдлаар зогсонги байдалтай байна. Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж үзэхэд хүргэж байна.

Иймд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа ТАХ-ний үр ашгийг сайжруулах үүднээс аль болох үр дүнтэй, ашиглагдахуйц ТАХ-г эн тэргүүнд хэрэгжүүлэх чиглэлийг баримтлан, ашиглалтгүй байгаа хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, урсгал зардлыг тооцож шийдвэрлээгүйгээс хөрөнгө ашиглалтгүй, үр дүнгүй болох эрсдлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах талаар зөвлөмжийг хүргүүлээ.

4.2 Нийтийн эзэмшлийн бүтээн байгуулалтын хөрөнгийн ашиглалтанд тавих хяналт сул байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г холбогдох байгууллагын санхүү бүртгэлд бүрэн тусгасан бөгөөд ашиглагч байгууллагын зүгээс нийтийн эзэмшлийн зам талбай, гэрэлтүүлэг, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг бүтээн байгуулалтуудад бүрэн хяналт тавьж чадахгүй байгаагаас одоогийн байдлаар ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6²¹, Сангийн Сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 4.2²²-д заасны дагуу захиалагч гэрээний биелэлтийг хянаж, дүгнэж хэвшээгүй, сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг ихэвчлэн ЗДТГ-ын ажилтнууд тавьж байна. Эдгээр ажилтнууд нь захиалагчийн хяналт тавихад мэргэжлийн чадвар дутмагаас гүйцэтгэгч байгууллагад шаардлага бүрэн тавьж чаддаггүй, зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжгүй, захиалагчийн хяналтын зардал байхгүй, зарим сумын удирдлага энэ зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүйгээс ОНХС- аас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр үр дүнгүй, төсөл, дутуу, хугацаандаа хэрэгждэггүй зөрчил давтагдахад хүргэж байна. Тухайлбал:

- Цэцэрлэг сум 25.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий сумын төвийн гэрэлтүүлэг, тохижилтын ажлыг зохион байгуулахдаа техникийн даалгавар болон ажлын гүйцэтгэл өөр байхад ажлыг хүлээн авсан, ажлын явцад захиалагчийн хяналт хийгдээгүй, мэргэжлийн хүнийг ажил хүлээн авах комисст оруулаагүй байна.
- Эрдэнэмандал сум 2015 онд аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв замын засварын ажил”-ыг Голомт Констракшн ХХК-аар гүйцэтгүүлж ашиглалтанд хүлээж авсан, 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр 7.1 сая төгрөгөөр дээрхи компаниар зам засварын ажлыг давтан гүйцэтгүүлсэн боловч ажлын гүйцэтгэлийн хувьд чанаргүй, хяналт сул, ашиглалт хангалтгүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Мөн тус суманд ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд сумын төвийн гэрэлтүүлэгийн ажлыг хийж гүйцэтгэсэн ч одоог хүртэл урсгал зардлыг шийдвэрлэж чадаагүйгээс ашиглагдахгүй, эвдрэл гэмтэл гарч түүнд хяналт тавих байгууллага байхгүйд хүрээд байна.

4.3 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага зөвлөмжийг 90.4 хувийн биелэлттэй байна.

²¹ 46.1.6 дахь заалт "Бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэнд хяналт тавих"

²² Захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын, шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана"

Аймгийн Аудитын газраас ОНХС-ийн 2013-2015 оны хөрөнгийн зарцуулалтын байдалд хийсэн аудитаар нийт 3960.5 сая төгрөгийн зөрчил илэрч 90.4 хувийн биелэлттэй байна.

Төлбөр зөрчлийн нэгтгэл/ сая.төг/

он	илэрсэн зөрчил	Актны хэрэгжилт		Албан шаардлага		Зөвлөмж		хариуцлага		
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь	тоо		бие
2013	1198.9	27.3	100%	1085.6	100%	86.0	100%		-	
2014	2232.7	11.8	100%	795.1	97%	1425.9	100%	20	20	100%
2015	528.9	5.5	15%	528.3	100%		100%			
2016	1136.5	1.8		1134.7				1		

- 2014 оны 367.4 сая төгрөгийн 2 албан шаардлага биелэгдээгүй бөгөөд хуулийн байгууллагад шилжүүлсэн байдалтай байна.
- 2015 оны 5.5 сая төгрөгийн акт 15%-ийн биелэлттэй байгаа бөгөөд 2.2 сая төгрөг хууль хяналтын байгууллагад шилжигдсэн, 2.5 төгрөгийг 2017 оны 11 сард бүрэн барагдуулах хүсэлт ирүүлсэн байна. /Хангай сумын тоот албан бичиг/

2016 оны ОНХС-ийн аудитаар нийт **1,136.5** сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс **1.8** сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоож, **1134.7** сая төгрөгөнд албан шаардлага хүргүүлж хүргүүлж, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн засаг даргад хүргүүллээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүн, тайланд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу төлөвлөж, сумдад олгох шилжүүлэгийг бүрэн олгосон байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд захиалагчийн зүгээс бүрэн хяналт тавьж ажиллаж чадахгүй байна.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн байдалд хууль, журмын хүрээнд дотоод хяналт тавьж ажиллаагүй байна.
4. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд хэвийн ашиглагдаж байгаа ч зарим ТАХ-ний урсгал зардлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын байдалд хийсэн Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Б.Өсөхбаяр танаа:

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1, 9.4 дэх заалтуудын дагуу аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, сайн дурын идэвхитэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийж ажиллах нь зүйтэй байна.

Аймгийн засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Мөнхнасан танаа:

1. Сумдад баригдаж буй Барилга байгууламж, их засварын ажлын явц болон гүйцэтгэлийг хүлээн авахад мэргэжлийн хүн заавал оролцуулж, захиалагчийн зүгээс хяналт тавьж ажиллахыг удирдлагаас бодлогоор зохицуулж өгөх,
2. ТБОНӨХБАҮХАТХуулийг мөрдөж ажиллаагүй нийтлэг зөрчлүүд илэрч байгаатай холбогдуулан сумдын санхүү албаны даргыг энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалт, зохион байгуулж, хууль тогтоомж түүнтэй холбогдон гарсан журам зааврыг мөрдөж ажиллахад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Аймгийн ХБХОТХ-ийн дарга П.Энхтайван танаа:

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг гарган аймгийн засаг даргад танилцуулж, шаардлагатай бол ИТХ-аар хэлэлцүүлж хэвших, цаашид хэрэгжүүлэх шаардлагагүй төсөл арга хэмжээг зогсоож төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, мөн 2013-2016 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн талаар нэгдсэн суурь судалгааны сан бүрдүүлж ажиллах